

*Г.Анхзаяа - ХСИС, Хууль сахиулахын удирдлагын
академийн 8072 дугаар дамжааны суралцагч,
цагдаагийн ахмад*

*А.Гантуул -ХСИС, Хууль сахиулахын удирдлагын
академийн Удирдахуйн ухааны профессорын багийн
дэд профессор, цагдаагийн хошууч*

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛ, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

***Хураангуй:** Энэхүү өгүүллээр хөдөлмөрийн нөхцөл, түүнд нөлөөлөх сөрөг хүчин зүйлс нь шүүхийн шинжилгээний алба хаагчдын эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг дүгнэж түүнийг хэрхэн шийдвэрлэх саналыг дэвшүүлээ.*

***Түлхүүр үг:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөл, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө.*

Оршил: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй гэдэг нь ажилтны ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалах, эрүүл, аюулгүй нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт эмчлэх, сувилах, нөхөн сэргээх, эрсдлээс хамгаалах цогц үйл ажиллагаа юм.

Ажилтны хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах нь хөдөлмөрийн хууль, тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн орчны хүчин зүйлийн нөлөөллийг бууруулж үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг арилгах тухай ойлголтыг хамааруулж үзэх тухай асуудал байдаг байна.

Хөдөлмөрийн нөхцөл нь хөдөлмөрлөх явцад ажилтны хөдөлмөрийн чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны орчны хүчин зүйлийн цогцолборыг хэлнэ.¹

Үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлийг хөдөлмөрийн нөхцөлийн сөрөг хүчин зүйл гэх бөгөөд түүнийг дотор нь:

4- Физикийн

4 Химийн

4 Биологийн

4 Сэтгэлзүй-физиологийн гэж 4 бүлэгт хуваана.

Физикийн ажлын бүсийн тоосжилт, ажлын бүсийн агаарын температур, чийг, шуугиан, байгалийн гэрэл байхгүй буюу дутагдалтай, гэрлийн шууд ба ойсон гялбалт, өнцөг ирмэг, газраас /шалнаас/ харьцангуй өндөр байрласан ажлын байр зэрэг аюултай хүчин зүйлүүдийг хамааруулна.

Химийн аюултай ба хортой хүчин зүйлд химийн бодисууд хамрагдана.

Биологийн аюултай ба хортой зүйлд ургамал амьтанаас хүнд, хүнээс хүнд халдварлах өвчний үүсгүүр болох халдварт өвчтэй ургамал, амьтан, хүн тэдгээрийн ялгадасаар бохирдсон эд юмс, бүтээгдэхүүн, эмгэг төрөгч бичил организмууд /нян, вирус, риккетси, мөөгөнцөр г.м/ хамаарна.

Сэтгэлзүй-физиологийн аюултай ба хортой хүчин зүйл нь хөдөлмөрлөх, ажил үүрэг гүйцэтгэх явцад хүний эрүүл мэндэд нөлөөлөх биеийн хүчний болон мэдрэл сэтгэхүйн ачаалал юм.

Ачаалал ангилан авч үзвэл:

Биеийн хүчний ачаалалд нэг ба хоёр гараар, мөн бүх биеэр ачааг хөдөлгөөнгүй барих, чөлөөтэй эсвэл хязгаарлагдмал орон зайд хөдөлгөөнгүй эсвэл янз бүрийн байдлаар бөхийж албадмал байдлаар болон хол явж гүйцэтгэх ажил /статик ачаалал/, эсвэл гар, мөр, хөл, их биеийн булчин оролцож ачааг өргөж зөөх /динамик ачаалал/ ажлыг тус тус хамруулна.

Мэдрэл сэтгэхүйн ачаалалд сэтгэн бодох, тогтоож авах, дүгнэлт гаргах зэрэг оюун ухааны хэт ачаалал, анхаарал төвлөрүүлэх, ажиглах, хүртэх, сонсох зэрэг мэдрэхүйн эрхтний болон хөдөлмөрийн нэгэн хэвийн залхаасан байдал, уурлах, бухимдах зэрэг сэтгэл хөдлөлөөс үүсэх ачааллыг хамруулна¹.

Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын эрүүл мэндэд сэтгэлзүй-физиологийн сөрөг нөлөөлөл түгээмэл тохиолдож байгаа нь судалгааны дараах үр дүнгээс харагдаж байгаа юм.


Судалгаа №1

Санал асуулгад Шүүхийн шинжилгээний байгууллагын нийт 153 алба хаагч хамрагдсанаас 36 алба хаагч буюу 23,5 хувь нь биеийн хүчний ачаалал их, 43 алба хаагч буюу 29,6 хувь нь мэдрэл сэтгэхүйн ачаалал, 74 алба хаагч буюу 46,9 хувь аль аль нь адил хэмжээний хор хөнөөл үзүүлдэг гэж хариулжээ. Үүнийг графикаар харуулбал:

¹ШУТИС, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний хороо., "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа", 2006 он. 20 дахь тал

Хөдөлмөрийн нөхцлийн хор хөнөөл

■ Биений хүчний ачаалал их ■ Мэдрэл сэтгэхүйн ачаалал их ■ Аль аль нь адил



Дээрх графикаас харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь мэдрэл сэтгэхүйн ачаалал, биений хүчний ачаалал аль аль нь их байдаг гэж хариулж байгаад дүгнэлт хийж үзэхэд энэ нь тэдний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх шалтгаан болж болох талтай байна.

Мэдрэл сэтгэхүйн болон биений хүчний ачаалал их байгаа шалтгаан нөхцлийг тогтоох зорилгоор "Та өөрт биений хүчний ачаалал болон мэдрэл сэтгэхүйн ачаалал үүсгэдэг шалтгаануудыг нэрлэнэ үү" гэсэн асуултад:

Мэргэжилтэн, шинжээч нар:


Бие хүчний ачаалал:

- >Хэргийн газрын үзлэг хүйтэн, нойтон, халуун, шороотой, бороотой, өндөрлөг газар, хад асгатай гэх мэт янз бүрийн орчин нөхцөлд техник урвалж бодис ашиглан ул мөрийг илрүүлэх бэхжүүлэн авах,
- >Хэргийн дууддага мэдээлэл газар орон нутаг дэвсгэрээс шалтгаалан хол явган явж үзлэгийн цүнх, аппарат, гар чийдэн бусад хэрэгслийг авч явах,

Мэдрэл сэтгэхүй ачаалал:

- > Хэргийн газрын үзлэгт ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэхийн тулд хэргийн газрын үзлэгт анхаарал төвлөрүүлэх, харах, ажиглах, хүртэх, сонсох зэрэг мэдрэхүйн эрхтний ашиглан гэмт үйлдлийн мөрийг унших, илрүүлэх, олж тогтоох , бэхжүүлэх ажиллагаанд
- > Хүн нас барсан, хулгай дээрэм бусад гэмт хэргийн дуудлаганд очиход айж цочирдох зэргийг нэрлэжээ.

Хөдөлмөрийн нөхцлийн сөрөг нөлөөнд ажилладаг уу?



Шинжээч,
мэргэжилтэн
ажлын байрны
онцлогоос
хамаарч
биологи,
хими, физик,
сэтгэлзүйн
хортой
нөлөөнд
ажилладаг уу?
гэсэн асуултад

2 хувь нь огт үгүй гэсэн сонголтыг хийсэн алба хаагч "гарын хээний санч" нар бөгөөд 73 хувь нь байнга, 25 хувь нь заримдаа гэсэн хариулсан байна. Эндээс үзэхэд дийлэнх алба хаагчид "шинжээч эмч, криминалистикийн шинжээч, биологийн шинжээч, эдийн засгийн шинжээч, химийн шинжээч" нар хөдөлмөрийн нөхцлийн сөрөг нөлөөнд ажиллаж байна.

"Шүүхийн шинжилгээний алба хаагчдын хөдөлмөрийн нөхцлөөс шалтгаалан үүсч буй хими, физик, биологи, сэтгэлзүй-физиологийн хор нөлөөг хэрхэн арилгах талаар та ямар саналтай байна вэ?" гэсэн асуултад давхардсан тоогоор:

Хими, биологи, сэтгэлзүйн хор нөлөөг арилгах:

>Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж өгөх "тусгай зориулалтын хувцас бусад хэрэглэлээр бүрэн хангах",

>Ажлын байрны эрүүл аюулгүй ажиллагааг хангах.

Сэтгэлзүй-физиологийн хор нөлөөг арилгах:

Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, стресс тайлах аргад сургах сэтгэл зүйчийн орон тоог нэмэгдүүлэх,

Алба хаагчдын стрессэтайлах орчин нөхцөлийг бүрдүүлж, энэ чиглэлийн зөвлөх үйлчилгээг үзүүлж байх.

Амралтыг биеэр заавал эдлүүлэх,

Бие хүчний дасгал хийх, алба хаагчдыг чийрэгжүүлэх спорт заал. тусгай тохижуулсан бэлтгэлийн танхим байгуулах зэрэг саналыг дэвшүүлж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтний ажиллах нөхцөл, баталгаанд хамаарах үндсэн асуудлын нэг тэдгээрийн эрүүл мэндийн асуудал байдаг.

Судалгаа №2

Энэхүү судалгаа нь шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх сөрөг хүчин зүйлсийг тогтооход чиглэгдсэн.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн улсын стандарт /MNS 4967:2000/-д тодорхойсоноор:

Мэргэжлээс шалтгаалсан өвчин гэдэг нь ажилтан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад ууссэн үйлдвэрлэлийн сөрөг /хортой/ хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалсан өвчин гэжээ¹.


Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид тэр дундаа шинжээч, мэргэжилтэн нар ажлын үүргийн онцлогоос хамаарч тэдний эрүүл мэндэд хөдөлмөрийн нөхцлийн сөрөг нөлөө үзүүлж байгаа нь мэргэжлээс шалтгаалах өвчлөн үүсгэх нэг шалтгаалсан болоод байна.

Санал асуулгаар: Та шүүхийн шинжилгээний албанд орж ажилласанаас хойш мэргэжлээс шалгаалсан өвчтэй болсон уу? гэсэн асуултад:

153 алба хаагч буюу 69,3% тийм гэж хариулсан бол

47 алба хаагч буюу 30,7% нь үгүй гэж хариулжээ.

Мэргэжлээс шалтгаалсан өвчтэй эсэх?




■ Тийм
■ Үгүй

Санал асуулгад тийм гэж хариулсан алба хаагчдын ихэнхи нь шүүхийн шинжилгээний байгууллагад 5 ба түүнээс дээш жил ажилласан алба хаагчид байсныг дурьдах хэрэгтэй болов уу.

Эдгээр алба хаагчдаас “Мэргэжлээс шалтгаалсан өвчтэй болоход нөлөөлсөн хүчин зүйлийг нэрлэнэ үү?” гэсэн асуултад давхардсан тоогоор доорхи байдлаар хариулсан байна. Үүнд:

Мэргэжлээс шалтгаалах өвчин

нуруу өвдөх



Мэргэжлээс шалтгаалах өвчтэй болсон алба хаагчдад эмнэлгийн үйлчилгээ авах боломж ажлын ачааллаас шалтгаалан тэр бүр гардаггүй, эмнэлгийн тусламж авлаа гэхэд өвчнөө эдгэртэл эмчилгээ хийлгэж чаддаггүй гэдгээ онцлон тэмдэглэж байсныг дурьдах нь зүйтэй.

Дүгнэлт

Хүний оршин тогтнох гол үндэс нь түүний үйл ажиллагаа буюу хөдөлмөр юм. Иймд хүн амьдралынхаа ихэнх хугацааг ажлынхаа байранд өнгөрөөдөг бөгөөд тэрээр хөдөлмөрийн буюу мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлд илүү ихээр өртдөг. Үүнийг үйлдвэрлэлийн осол гэмтэл, золгүй явдал, мэргэжлээс шалтгаалсан өвчин зэргийн шалтгаан нөхцөлд хийсэн судалгааны үр дүн гэрчилж байна. Эдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсээс хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, журам, заавар хангалтгүй, тэдгээрийг сахиж мөрдөх орчин нөхцөл бүрдээгүйгээс гадна тохиолдож болзошгүй осол аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах болон даван туулах арга замын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг шалтгаан зонхилж байна.

Санал

Иймд судлаач миний зүгээс онолын болон практик ач холбогдолтой дараах саналыг дэвшүүлж байна:

- > Хууль, эрх зүйн орчинг сайжруулж, байгууллагын эрх зүйн баримт бичгийг боловсронгуй болгох- хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах алба хаагчдын баталгааг сайжруулах. Жишээ нь Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагууд хуулиудын шинэчлэн найруулгын хүрээнд хууль эрх зүйн баталгаа, нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгаа, аюулгүй байдлын баталгаа, улс төрийн баталгааг зэргийг тусгаж авч үзсэн нь алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах,
- > Шинжээч, мэргэжилтэн нарын мэргэжлийн аюулгүй ажиллагааг хангасан нэг бүрийн хэрэгсэл. ажлын тусгай хувцасны

үлгэрчилсэн загварыг гаргах, энэ чиглэлээр сургалтыг тодорхой үе шаттайгаар явуулах.

- > Хөдөлмөрийн нөхцлийн сөрөг хүчин зүйлээс мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт алба хаагч нарыг тогтмол хамруулж, улирал бүр сорил тавиулж эрүүл мэндэд тогтмол анхаарах зэрэг саналыг дэвшүүлж байна.